



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

### БУЛГАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Анхбаяр  
Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.09.24 № 147

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Н.ХИШИГДОРЖ  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Шатар сайдтай аймгийн Засаг дарга 2025 онд хамтран ажиллах гэрээний дагуу тус аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт зохион байгуулан ажилласан байна.

Аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт, 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### Аудитын гол асуудал

2025 оны Онцгой байдлын газрын даргын А/01 тушаалаар 2025 онд батлагдсан орон тоо 152, гүйцэтгэлээр 132 албан хаагч ажиллаж байна 20 албан хаагчдын орон тоо дутуу ажиллаж байна. Гал сөнөөгч 6, техник хариуцсан мэргэжилтэн 1, сэтгэл зүйч 1, цэргийн хэргийн мэргэжилтэн 1, гамшгаас хамгаалах байцаагч 1, аврагч 5, агарномч 2, жолооч 3 зэрэг орон тоо дутуу ажилласан байна.

6326050118

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31.	2025.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,389,881.97	883,726.77
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,033,170.62	5,058,383.67
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	6,423,052.59	5,942,110.45
	Нийт өр төлбөрийн дүн	-	369.84
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,423,052.59	5,941,740.61
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	6,423,052.59	5,942,110.45
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,943,356.69	6,969,092.88
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,022,165.86	6,434,293.88
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	921,190.82	534,799.00
	Үйл ажиллагааны бус үр дүн	(1,083,052.49)	(1,016,110.98)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	(161,861.66)	(481,311.98)
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,584,914.26	6,423,052.59
	Тайлант оны үр дүн	(161,861.66)	(481,311.98)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	6,423,052.59	5,941,740.61
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,854,864.20	5,711,674.67
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,825,064.40	5,711,674.67
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	29,799.80	-
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	(29,799.80)	-
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	-	5,408,392.42
	Урсгал зардал	-	5,408,392.42
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	-	5,408,392.42
	Улсын төсвөөс санхүүжих	-	5,408,392.42
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Онцгой байдлын газар /цаашид ОБГ/ нь “Гамшиг аюулт үзэгдэл ослоос хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэн зүйлсийг гамшгаас хамгаалах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино”, “Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд стандарт, мэдээллийн технологийн шинэчлэлт хийж, гамшгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн санг

хөгжүүлэх”, “Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг сайжруулах, ёс зүйн сахилга хариуцлагыг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Онцгой байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь ОБЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 15 –ны өдрийн А/293 дугаар тушаалаар баталсан НБББББ-ыг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Шатар сайдтай аймгийн Засаг дарга 2025 онд хамтран ажиллах гэрээний дагуу тус аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт зохион байгуулан ажилласан байна.

Аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт, 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

2025 оны Онцгой байдлын газрын даргын А/01 тушаалаар 2025 онд батлагдсан орон тоо 152, гүйцэтгэлээр 132 албан хаагч ажиллаж байна 20 албан хаагчдын орон тоо дутуу ажиллаж байна. Гал сөнөөгч 6, техник хариуцсан мэргэжилтэн 1, сэтгэл зүйч 1, цэргийн хэргийн мэргэжилтэн 1, гамшгаас хамгаалах байцаагч 1, аврагч 5, агрономч 2, жолооч 3 зэрэг орон тоо дутуу ажилласан байна.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

##### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

##### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 338,847.2 мянган төгрөгийн шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн аудитаар санхүүгийн тайлангийн тодруулгыг журамд нийцүүлсэн бэлтгэсэн эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 351,049.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,777.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 346,049.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

### **Төлбөрийн акт**

1. Аймгийн засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/607 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д идэвх санаачилгатай оролцсон алба хаагчдад урамшуулал олгосон нь хууль, тогтоомжтой нийцэхгүй байна. Онцгой байдлын газрын дарга Н.Хишигдоржид 1,985.0 мянган төгрөг, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Болдбаатарт 1,800.0 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон зөрчил илэрсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэсэн заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хууль, тогтоомж зөрчиж урамшуулалд олгосон нийт 3,785.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. Аймгийн засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/794 дугаар захирамжийг үндэслэн Онцгой байдлын газрын дарга Н.Хишигдоржид 992.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь хууль, тогтоомжид нийцэхгүй зөрчил илэрсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэсэн заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хууль, тогтоомж зөрчиж урамшуулалд олгосон 992.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### **Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал:

*Илрүүлэлт:* Жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 7,054.9 мянган төгрөг, газрын төлбөр дутуу төлсөн өглөг 369.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага болон өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 338,847.2 мянган төгрөгийн шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5. "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А.Т тоо	Тоо	Дүн	
Аймгийн засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/607 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д идэвх санаачилгатай оролцсон алба хаагчдад урамшуулал олгохдоо үндэслэсэн хууль, тогтоомж нь урамшуулал олгоход нийцэхгүй байна. Онцгой байдлын газрын дарга Н.Хишигдорж, Онцгой байдлын газрын ахлах мэргэжилтэн Ж.Болдбаатар нарт нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулалд нийт 3,785.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн.	1	3,785.0	1	3,785.0									
Аймгийн засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/794 дугаар захирамжийг үндэслэн 992.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь хууль, тогтоомжид нийцэхгүй байна.	1	992.5	1	992.5									
Жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлын авлага 7,054.9 мянган төгрөг, газрын	1	7,424.7					1	7,424.7					

төлбөр дутуу төлсөн өглөг 369.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.												
Дүн	3	12,202.2	2	4,777.5			1	7,424.7				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	338,847.2					1	338,847.2
Дүн	1	338,847.2					1	338,847.2